

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын тайлан



Шилэн данс

Шилэн дансны зарчим /4-р зүйл/

- Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;
- Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;
- Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;
- Хуулийн дагуу нууцад хамваруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Бүтээгдэхүүн	Мэдээлэл	Харилцагчид	Хуульчилсан
Аудитын тайлан	Тасвирын гүйцэтгэл	Мэдээлэл	Зарим

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Агуулга

<p>Аудитын гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт</p>	<p>1</p>
<p>ҮАГ-ын харьяа Ховд аймаг дахь аудитын газар</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл</p>	<p>2</p>
<p>Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар</p>	<p>Бүлэг 1. Шилэн дансны цахим хуудсанд хамрагдвал зохих байгууллагуудын 97.8 хувь нь цэсээ нээлгэж мэдээлж байгаа ч мэдээллийн ил тод, үнэн зөв, иж бүрэн мэдээлэх талаар хангалтгүй байна.</p>	<p>3</p>
<p>Аудитын менежер А.Цэцэгсүрэн</p>	<ul style="list-style-type: none"> Шилэн дансны нээгдсэн сайтад 185 байгууллага мэдээллээ байршуулахаас 97.8 хувь буюу 181 байгууллага цэс нээлгэж 2.2 хувь буюу 4 байгууллага цэс нээлгээгүй байна. 	<p>3</p>
<p>Аудитор Б.Дамчубалжир Ц.Азаяа</p>	<ul style="list-style-type: none"> Шилэн дансны тухай хуулийн 5.0 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээний мэдээлэлт өмнөх оноос сайжирсан ч тогтмол мэдээлэх мэдээлэл болох төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт, жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл зэрэг мэдээллүүдийг бүрэн мэдээлж хэвшээгүй байна. 	<p>3</p>
<p>2018 оны 11 дүгээр сар</p>	<ul style="list-style-type: none"> Байгууллагууд мэдээллийг ил тод, үнэн зөв, иж бүрэн мэдээлэх талаар хангалтгүй байна. 	<p>5</p>
<p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn</p>	<p>Бүлэг 2. Төрийн чиг үүрийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж төсвөөс санхүүжилт авсан аж ахуй нэгжүүд Шилэн дансны хуульд заасан мэдээлэл байршуулах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байна.</p>	<p>6</p>
<p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.</p>	<ul style="list-style-type: none"> Ховд дулааны станц үйлдвэрийн газар нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласнаар хуулийг хэрэгжүүлэлтэнд ахиц гарсан байна. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжүүд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага, аж ахуй нэгжүүд хуульд заасан мэдээллүүдээ байршуулаагүй байна. 	<p>6 7</p>
<p>ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймаг дахь Төрийн аудитын газар 3 давхар</p>	<p>Бүлэг 3. Төрийн аудитын байгууллага, СХАА-аас хяналтыг хэрэгжүүлж зөвлөмж, албан шаардлага өгч байгаа ч 2018 онд шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сургалт сурталчилгаа, хариуцлага тооцогдохгүй байгаагаас байгууллагуудын мэдээлэлт өмнөх оноос сайжрахгүй байна. Бүх шатны ИТХ, багийн ИНХ-аас хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.</p>	<p>8</p>
	<ul style="list-style-type: none"> Аймаг, сумдын ИТХ, багийн ИНХ-ын байгууллагууд хуулийн 8.1 -д заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас улирал бүр хяналт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хуулийн хэрэгжилтийг хангуулах зөвлөмжийг аймгийн ТЭЗ, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байгаа ч холбогдох байгууллагууд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 	<p>8 9</p>
	<p>Аудитын дүгнэлт</p>	<p>11</p>
	<p>Аудитын зөвлөмж</p>	<p>12</p>
	<p>Тэргүүлэх Аудиторын тушаал</p>	
	<p>Албан шаардлага, зөрчлийн нэгтгэл.....</p>	
	<p>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар:.....</p>	
	<p>Хавсралт судалгаанууд.....</p>	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ААГ	Аймгийн Аудитын газар
НА	Нийцлийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлдвэрийн газар
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ААН	Аж ахуйн нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
БСУГ	Боловсрол соёл урлагын газар
НДС	Нийгмийн даатгалын сан
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба

1.1. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 06 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/06 тоот тушаалаар батлагдсан Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Үндэслэл, зорилт, хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ.

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх

1.3 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа:

Энэхүү аудитад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Ховд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд, төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдийг 2017-2018 оны шилэн дансны мэдээлэлд үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.


ҮАГ-аас ирүүлсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу аймгийн СХДАА-наас хийсэн хяналтаар эрсдэлтэй гарсан, өмнөх аудитаар хангалтгүй мэдээлсэн байгууллагууд, өмнө онд итгэл үзүүлж хамруулаагүй 107 байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянаж 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 27-ныг хүртэл хугацаанд нийцлийн аудит хийлээ.

Аймаг, сумдын төрийн сан, сумдын төрийн сангийн хуулгыг татан авч холбогдох хөрөнгө, гүйлгээ, тайлан зэрэг мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлсэн эсэхийг нягталж эрсдэлтэй гэж үзсэн сумдад томилолтоор ажиллан газар дээр нь танилцаж арга зүйн зөвлөгөө өгч аудитыг гүйцэтгэв.

Бүлэг 1. Шилэн дансны цахим хуудсанд хамрагдвал зохих байгууллагуудын 97.8 хувь нь цэсээ нээлгэж мэдээлж байгаа ч мэдээллийн ил тод, үнэн зөв, иж бүрэн мэдээлэх талаар хангалтгүй байна.

Шилэн дансны нэгдсэн сайтад 185 байгууллага мэдээллээ байршуулахаас 97.8 хувь буюу 181 байгууллага цэс нээлгэж 2.2 хувь буюу 4 байгууллага цэс нээлгээгүй байна.

1.1 Ховд аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.1¹-д заасан 172, 3.1.2²-т заасан 5, 3.1.3³-д заасан 4, бүгд 181 байгууллага хамрагдаж байна. Эдгээр 181 байгууллагаас гадна 2018 онд шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа Алтай, Зэрэг сумдын “Шим-ус” ОНӨААТҮГ, Минжит булган хот тохижилт, Тээлийн илч ОНӨААТҮГ зэрэг 4 байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгүүлж цэс нээлгээгүй байна.



1.2 Аймгийн Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс, Чандмань БИТ, Эрч хүч ОНӨҮГ нь татан буугдсан ч тус байгууллагын цэсийг хаалгаж шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас хасуулаагүй байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст "Ховд албан бус боловсрол төв", "Ховд аймаг Жаргалант сум Албан бус боловсролын төв", "Ховд аймаг Нийгмийн даатгалын сан" гэсэн цэсүүд давхардан нээгдсэн байна

Шилэн дансны тухай хуулийн 5.0 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээний мэдээлэлт өмнөх оноос сайжирсан ч тогтмол мэдээлэх мэдээлэл болох төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт, жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл зэрэг мэдээллүүдийг бүрэн мэдээлж хэвшээгүй байна.

1.3 Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг 52.5 хувь, хагас жилийн төсвийн болон өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 87.2 хувь, дараа жилийн төсвийн төслийг 43.4 хувь, жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайланг 54.2 хувь, төсвийн

¹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² төрийн өмчит үйлдвэрийн газар

³ хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани

ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг 44.6 хувь, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 19.8 хувьтай тус тус мэдээлсэн байна. Үүнээс үзэхэд төрийн болон төрийн өмчит байгууллагууд нь төсвийн гүйцэтгэлийг сар, улирал, хагас, бүтэн жилээр тогтмол мэдээлж хэвшсэн боловч төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг мэдээлж хэвшээгүй байна.

- 1.4 Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг 38 байгууллагад 9400.6 сая төгрөгийн 344 гүйлгээ гарсныг бүрэн мэдээлсэн байна. 2017 оны 10 сарын 01-ээс 2018 оны 10 сарын 01-ний хооронд нийт аймгийн хэмжээнд цалингийн зардлаас бусад орлого зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлсэн байдлыг хянаж үзэхэд нийт 46163.7 сая төгрөгийн 1165 орлогын гүйлгээ гарснаас 46.0 хувь буюу 22030.4 сая төгрөгийн 536 гүйлгээг мэдээлсэн, 9015.2 сая төгрөгийн 543 зарлагын гүйлгээ гарснаас 74.8 хувь буюу 8658.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх байдлаас үзэхэд ихэнх байгууллагууд сар бүрийн санхүүжилтийн орлогыг мэдээлж хэвшээгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээний мэдээлээгүй тоог өмнөх аудитын дүнтэй харьцуулж графикаар харуулбал:



- 1.5 Аймгийн хэмжээнд хуулийн 6.1-д заасан тогтмол мэдээлэх мэдээллийг 73.4 хувь, 6.4-д заасан 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийг 68.9 хувь мэдээлсэн дүнтэй байна.
- 1.6 Долоо хоногийн дотор мэдээлэх тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан

Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх мэдээлэл	Нийт		Үүнээс: мэдээлээгүй	
	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	344	9400.6	0	0
6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	543	9015.2	141	1724.5
6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	1165	46163.7	629	24133.3
Нийт	2052	64579.5	770	25857.8

болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэрэг мэдээллүүдийг 95 хувьтай мэдээлсэн байна.

- 1.7 Харин бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухайн ажил гүйлгээ гараагүй гэж мэдээлсэн байна.



- 1.8 Зарим байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулахдаа хугацаа хоцроон мэдээлж байна. Энэ нь мэдээллийг хариуцаж байршуулдаг албан тушаалтны ажлын хариуцлага хангалтгүй, мөн хөдөө сумдад интернет сүлжээний хурд доголдол гардаг зэрэгтэй холбоотой байна.

Байгууллагууд мэдээллийг ил тод, үнэн зөв, иж бүрэн мэдээлэх талаар хангалтгүй байна.

- 1.9 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг оруулалгүйгээр тухайн цэсний баталгаажуулах товчийг дарж хоосон мэдээлсэн байгууллагууд байна. Үүнд: Үенч сумын ЗДТГ, ИТХ, Сургууль, Соёлын төв, Булган сумын 2 дугаар цэцэрлэг, 2 дугаар сургууль, Дарви сумын ЗДТГ, Соёлын төв зэрэг байгууллагууд батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан зэрэг цэсэд оруулбал зохих мэдээллүүдийг оруулалгүй хоосон хадгалсан байгаа нь хуулийн 4.1.1⁴-д заасныг зөрчсөн байна.
- 1.10 Мэргэжлийн хяналтын газар, Ховд аймгийн Засаг даргын тамгын газар, БОЭТ, Жаргалант сумын 1, 3, 6-р сургууль, Биеийн тамир спортын газар, Шим-Ус ОНӨААТҮГ зэрэг газрууд дарга, санхүүгийн ажилтны нэрийг шинэчилж оруулаагүй Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх”, 5.1.4-т “Мэдээллийг тогтмол шинэчилж байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- 1.11 Хуулийн 6.1-д заасан тогтсон хугацаанд мэдээлэх мэдээлэлд нийт 2251 гүйлгээ мэдээлэхээс 11 хувь буюу 248 мэдээлэл, 6.4-д заасан 7 хоногийн дотор мэдээлэх мэдээлэлд 2596 гүйлгээ мэдээлэхээс 0.4 хувь буюу 10 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь 4.1.3⁵-д заасныг зөрчсөн байна.

⁴ Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

⁵ Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх

1.12 Аудитын явцад зарим байгууллагуудад ажиллаж мэдээллийн самбарыг шалгаж үзэхэд ХХҮГазар нь иргэдэд үйлчлэх танхимдаа цахим дэлгэц байрлуулан санхүүгийн болон өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллүүдийг цаг хугацаанд нь иргэдэд шуурхай хүргэж байгаа дэвшилттэй тал харагдаж байна. Харин Биеийн тамир спортын газар, Ховд дулааны станц ТӨХК зэрэг байгууллагууд санхүүгийн мэдээллийн самбараа санхүү албаны өрөөндөө байрлуулсан, Мэргэжлийн хяналтын газар, Буянт сумын цэцэрлэг, Соёлын төв, Мянгад сумын сургууль зэрэг байгууллагууд мэдээллийн самбарын мэдээллээ шинэчлээгүй байгаад нь иргэд олон нийтэд ил тод байх боломжтой байдлаар байрлуулах хуулийн 5.8-д заасан шаардлагыг хангах талаар холбогдох зөвлөмжийг өгч ажиллаа.



Бүлэг 2. Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж төсвөөс санхүүжилт авсан аж ахуй нэгжүүд Шилэн дансны хуульд заасан мэдээлэл байршуулах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

Ховд дулааны станц үйлдвэрийн газар нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласнаар хуулийг хэрэгжүүлэлтэнд ахиц гарсан байна.

2.1 Хуулийн 3.1.3-т хамаарах “Ховд дулааны станц ТӨХК” нь 2018 оны эхний 9 сарын байдлаар хуулийн 6.8.2⁶-т заасан мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, төсөл, арга хэмжээнд тендер зарлаагүй, зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотой тендерийн ерөнхий мэдээллийг бүрэн мэдээлжээ. Мөн Шилэн дансны тухай хуулийн 6.8.1⁷-д заасан мэдээллийг 20 шийдвэрийн 927.1 сая төгрөг мэдээлсэн байна. Өмнөх аудитаар “Ховд дулааны станц ТӨХК-д 1 албан шаардлага хүргүүлсний дагуу зөрчлийг арилгаж, хуулийг хэрэгжүүлж ажилласан байна. Аудитаар санхүүгийн ил тод байдлын самбарыг олон нийтэд ил тод харагдахуйц газарт байрлуулах талаар зөвлөмж өгч ажилласан.

Харин Ховд аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа Ховд АЗЗА, Ховд Нисэх буудал төрийн өмчит үйлдвэрийн газруудын хэрэгжилт эрсдэлгүй байсан тул түүвэрт хамруулж үзээгүй болно.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжүүд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.

2.2 Аудитаар аймгийн Орон нутгийн өмчийн газарт албан бичиг хүргүүлж судалгаа авахад худалдан авах ажиллагаанд оролцож хөрөнгө оруулалтын ажил

⁶ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

⁷ тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр;

хэрэгжүүлсэн 115 аж ахуйн нэгжид 8849.2 сая төгрөгийн санхүүжилт өгч ажлыг хийж гүйцэтгүүлсэн боловч Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Нөгөө төлөөс Ховд аймгийн Шилэн дансны цэсэд хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэж мэдээлсэн ямар ч аж ахуйн нэгж байхгүй байна. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4⁸-т хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9⁹ дэх заалтад заасны дагуу гэрээний үндсэн дээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээг нэг ч компани, аж ахуй нэгж байршуулаагүй байгаа нь нэг удаа тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгж шилэн дансны цахим хуудсанд цэс үүсгэж дараа нь мэдээлэл байршуулах шаардлага гарахгүйгээс системд ашиглагдахгүй цэсүүд байрших зэргээс шалтгаалж хуулийн холбогдох заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Иймээс цаашид хуулийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгжүүдийн шилэн дансанд байршуулах мэдээллийг энэхүү заалтын хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд батлагдсан маягтаар улирал бүр нэгтгэж, бүрэн мэдээлж байх албан шаардлагыг аймгийн ХОХБТХ-т хүргүүлэв.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага, аж ахуй нэгжүүд хуульд заасан мэдээллүүдээ байршуулаагүй байна.

2.3 Тус онд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.5 дахь заалтад хамаарах нийт 49 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас БСУГ-аас 13 аж ахуйн нэгж 450.9 сая төгрөг, НДС-аас 36 аж ахуйн нэгж 9790.5 сая төгрөг, нийт 10241.4 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр байгууллагууд шилэн дансны цахим хуудас нээлгээгүй, мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь санхүүжилт олгогч байгууллагуудын зүгээс хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар мэдлэг дутуу, гэрээ хийсэн байгууллагуудыг арга зүйгээр хангаагүй, санаачилга гаргаагүй зэргээс шалтгаалж байна.

Иймд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тендер шалгаруулах болон ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу мэдээллийг оруулах талаар гэрээнд тусгаж, гэрээг дүгнэхдээ мэдээлэл оруулсан байдалд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Гэтэл Өмнөговь, Баянхонгор аймгуудын 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуйн нэгж байгууллагууд нь өөрийн бие даасан цэс нээлгэж төсвөөс авсан санхүүжилтээ тогтмол мэдээлж хэвшсэн нь манай аймагтай харьцуулахад хуулийн хэрэгжилтийг

⁸ улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

⁹ Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.

хангаж ажиллах талаар идэвх санаачилга, хариуцлага, хяналттай байгааг харуулж байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд байгууллагынхаа нэрээр цахим хуудсанд цэс нээж, Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан журмын 19 дүгээр хавсралтын дагуу улирал тутам мэдээллийг оруулахад хүндрэлтэй асуудал байхгүй гэж аудиторын зүгээс үзэж байна.

Бусад аймгуудын ийм төрлийн байгууллагуудтай харьцуулахад манай аймаг цэс нээж хөтлөхгүй байгаа нь Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах дотоод хяналт хариуцсан албан тушаалтан, нягтлан бодогч, төсвийн захирагч нарын ажлын хариуцлага хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд БСУГ-ын дарга, ЭМНДХ-ийн дарга нарт хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

Бүлэг 3. Төрийн аудитын байгууллага, СХАА-аас хяналтыг хэрэгжүүлж зөвлөмж, албан шаардлага өгч байгаа ч 2018 онд шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сургалт сурталчилгаа, хариуцлага тооцогдохгүй байгаагаас байгууллагуудын мэдээлэлт өмнөх оноос сайжрахгүй байна. Бүх шатны ИТХ, багийн ИНХ-аас хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аймаг, сумдын ИТХ, багийн ИНХ-ын байгууллагууд хуульд заасан¹⁰ хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1 Аудитын шалгалтын хүрээнд аймгийн ИТХ-ын ажлын албанд шилэн дансны тухай хуулийн 8.1-дэх заалтыг хэрэгжүүлсэн тухай ажлын тайлан мэдээг гаргуулж авахаар 2018.10.31-ний №165 тоот албан бичиг хүргүүлэхэд 2018.11.19-ний №2/498 тоот албан бичгээр аймаг, сумдын ИТХ, багийн ИНХ-аас хөндлөнгийн ямар нэгэн хяналт хэрэгжүүлээгүй тухай хариу ирүүлсэн болно.

Иймд бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлаас хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж байхаар албан шаардлага өглөө.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас улирал бүр хяналт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хуулийн хэрэгжилтийг хангуулах зөвлөмжийг аймгийн ТЕЗ, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байгаа ч холбогдох байгууллагууд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг СТСХ-ээс боловсруулан аймгийн Засаг даргаар 2018 оны 5 сард батлуулсан байна. Уг төлөвлөгөөнд заасан ажлыг хариуцан хэрэгжүүлж ажиллахаар 6 албан тушаалтанд ажил үүргийг хуваарилснаас гадна сумдын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, төсөвт байгууллагын дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн нарт мөн хариуцуулжээ. Гэвч урьдчилсан байдлаар төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй,

¹⁰ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хуулийн хэрэгжилт хангуулах талаар 2 удаа бичиг боловсруулж өгсөн байна.

СТСХ-ээс Хууль эрхзүйн хэлтэст 2018.05.04 №5/973 тоот албан бичгээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй 8 байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах тухай албан бичиг хүргүүлсэн боловч хариуцлага тооцсон баримт материал ирүүлээгүй байна.

Харин Аймгийн Засаг даргын 2017.10.30-ны өдрийн А/558 тоот захирамжаар 40 байгууллагын дарга, эрхлэгч нарт сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ. Иймд уг байгууллагууд ажлын уялдаа холбоогоо сайжруулах, илэрсэн алдаа зөрчлийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч биелэлт тооцож ажиллах шаардлагатай байна.

3.3 Хуулийг хэрэгжүүлэх үүднээс төсөв захирагчийн үр дүнгийн гэрээнд төсвийн ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах талаар тусгасан заалтын биелэлтийг дүгнэхдээ энэ хуулийн 8.4¹¹ дэх заалтыг удирдлага болгон дүгнэх шаардлагатай байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.4 Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлт Төрийн аудитын байгууллага болон бусад хяналтын байгууллагуудад ирээгүй байна. Эндээс үзэхэд иргэдэд хууль сурталчлах ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 онд хийсэн аудитаар улсын төсөвт 3 байгууллага, орон нутгийн төсөвт 44 байгууллага, ОНӨҮГ-ын 2 байгууллага, ТӨҮГ-ын 1 байгууллага, нийт 50 байгууллагын төсвийн шууд захирагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлага өгөгдсөн байна. Албан шаардлагын биелэлт 75 хувьтай хэрэгжсэн байна.

№	Төлбөр, зөрчил хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Хэрэгжилт
	Нэр	Албан тушаал			
1	Д.Галсандондог	Аймгийн Засаг дарга	Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй	1/68	0
2	Ц.Мягмарсүрэн	Эрүүл мэндийн газрын дарга	Булган сумын хүн эмнэлэг нь шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй	2/69	100
3	В.Сайнбаяр	Ховд их сургуулийн захирал	Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй	3/70	100

¹¹ Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.

4	Д.Энхсайхан	Ховд дулааны станц ТӨХК	Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй	4/71	100
НИЙТ ДҮН					75

Харин ТЕЗ-д хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт бүрэн хэрэгжээгүй байна.

Д/д	Зөвлөмж өгөгдсөн албан тушаалтан	Зөвлөмжийн утга	Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байдал	Хэрэгжилтийн хувь
1		Шилэн дансны нэгдсэн мэдээлийн цахим хуудсанд мэдээллээ бүрэн оруулаагүй төсвийн шууд захирагч нарт хариуцлага тооцох.	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хүргүүлсэн албан бичгийн дагуу ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс Хууль эрхзүйн хэлтэст 2018.05.04 №5/973 тоот албан бичгээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй 8 байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах тухай албан бичиг хүргүүлсэн боловч хариуцлага тооцсон баримт материал манайд ирүүлээгүй нь дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж дүгнэх боломжгүй байна.	0
2	Аймгийн засаг дарга Д.Галсандондогт	Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй Улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэж ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААН-үүд, Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч болох хувийн цэцэрлэг, хувийн эмнэлэг, эмийн сангуудад төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг олгохгүй байх талаар гэрээндээ тодорхой тусгаж хариуцлагыг сайжруулж ажиллах.	Хэрэгжүүлээгүй	0
3		Шилэн дансны тухай хууль, эрх зүйн актуудыг сурталчилах ажлыг эрчимжүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, байгууллагын нягтлан бодогч нарыг нэгдсэн арга зүйгээр хангаж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж ажиллах.	Хэрэгжүүлээгүй	0
Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь /дунджаар/				0

Өмнө оны аудитын мэдээлээгүй гүйлгээний дүнг энэ оны аудиттай харьцуулахад мэдээлээгүй гүйлгээний тоо 40 хувиар буурсан үзүүлэлт гарч байгаа боловч бусад аймгийн мэдээлсэн хувьтай харьцуулахад манай аймаг хангалтгүй дүн гарч байна. Жишээлбэл: Баянхонгор аймаг 2018 оны тайлангаар 87.7%, Архангай аймаг 2017 оны тайлангаар 91.8%, Дорнод 2017 оны тайлангаар 97.0% гэх мэт:

Д/д	Мэдээллийн төрөл	2017	2018	Зөрчил өссөн, буурсан хувь /+, -/
1	Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	138	141	2
2	5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний	1072	629	-59

3	Тухайн жилийн батлагдсан төсөв	74	27	-36
4	ОНХС-ийн төлөвлөгөө	10	7	-70
5	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	11	14	27
6	Дараа жилийн төсвийн төсөл	109	60	-55
7	Хагас жилийн санхүүгийн тайлан	80	42	-53
8	Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	109	57	-52
9	Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, түүний тайлбар	139	85	-61
Мэдээлээгүй зөрчлийн дундаж				-40

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар улсын төсөвт 2 байгууллага, орон нутгийн төсөвт 28 байгууллага, нийт 30 байгууллагын төсвийн шууд захирагч нарт хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг төсвийн ерөнхийлөн захирагчид, 3.1.4, 3.1.5-д заасан хуулийн этгээдийн хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар 3 албан шаардлагыг холбогдох ТШЗ-д, аймгийн ИТХ-д хуулийн 8.1-д заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах талаар 1, бүгд 5 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулаагүйтэй холбоотой 15 төрлийн зөрчилтэй холбоотой 44948,4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1. Шилэн дансны цахим хуудсанд хамрагдвал зохих байгууллагуудын 97.8 хувь нь цэсээ нээлгэж мэдээлж байгаа ч мэдээллийн ил тод, үнэн зөв, иж бүрэн мэдээлэх талаар хангалтгүй байна.
2. Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж төсвөөс санхүүжилт авсан аж ахуй нэгжүүд Шилэн дансны хуульд заасан мэдээлэл байршуулах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байна.
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжүүд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.
4. Төрийн аудитын байгууллага, СХАА-аас хяналтыг хэрэгжүүлж зөвлөмж, албан шаардлага өгч байгаа ч 2018 онд шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сургалт сурталчилгаа, хариуцлага тооцогдохгүй байгаагаас байгууллагуудын мэдээлэлт өмнөх оноос сайжрахгүй байна. Бүх шатны ИТХ, багийн ИНХ-аас хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн Аймгийн засаг дарга Б.Дүгэржав-д зөвлөх нь:

1. Шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд шинээр үүсгэн байгуулагдсан байгууллагын цэсийг нээх, давхардсан болон татан буугдсан байгууллагын цэсийг хаах арга хэмжээ авах.
2. Төсөв захирагчийн үр дүнгийн гэрээг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн 8.4 дэх заалтыг хэрэгжүүлсэн эсэхийг харгалзан үзэж үнэлж дүгнэх.
3. Шилэн дансны тухай хууль, эрх зүйн актуудыг сурталчлах ажлыг эрчимжүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, байгууллагын нягтлан бодогч нарыг нэгдсэн арга зүйгээр хангаж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж ажиллах.
4. Шилэн дансны үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийг тодорхой болгож, зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг 2018 оны 12 дугаар сарын 25-ны дотор гаргаж ирүүлэх.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2018 оны 11 сар 30

Дугаар 36

Ховд

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 15.2.5 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторов А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3 дэх заалт, 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлан баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитор /Б.Дамчуубалжир/-д үүрэг болгосугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэст, ИТХ-ын тэргүүлэгчдийн хурал, засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аудитын багт хариуцуулсугай.

4. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хонгийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор /Б.Дамчуубалжир/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /А.Цэцэгсүрэн/-д тус тус даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР